

МОНГОЛ ХЭЛНИЙ УНШИХ БИЧИГ

蒙古语阅读教程

第二册

编者 张吉焕

中国人民解放军外国语学院

中亚南亚军事语言系

二〇〇四年十二月

前　言

ГАРЧИГ

1-р ХИЧЭЭЛ.....	1
"Сая долларын охин" оны шилдэг кино болов	
2-р ХИЧЭЭЛ.....	7
—、20-р зууны Хятадын зуун болохгүй	
—、Монголын говьд хятадууд эзэн суухыг хүсч байна	
3-р ХИЧЭЭЛ.....	13
—、Д. Сүхбаатар	
—、Жанжин Сүхбаатарыг оросууд хорлосон нь улам бүр	
батлагдсаар байна	
4-р ХИЧЭЭЛ.....	18
Компьютерын хор уршгаас хэрхэн сэргийлэх вэ?	
5-р ХИЧЭЭЛ.....	24
Тайваны монголчууд	
6-р ХИЧЭЭЛ.....	29
"Эх орончдын өдөр"-ийг өчигдөр анх удаа тэмдэглэв	
7-р ХИЧЭЭЛ.....	34
Монголын эрдэмтэд хорт хавдрын эсрэг эм бүтээж байна	
8-р ХИЧЭЭЛ.....	40
Та "арванхоёрдугаар сарын 29"-ний өдрийг мэдэх үү?	
9-р ХИЧЭЭЛ.....	47
Ленинийг хэн буудсан бэ?	
10-р ХИЧЭЭЛ.....	55
—、"Монголросцвэтмет"-ын ерөнхий захирал Х. Бадамсүрэн	
эрүүгийн хэрэг үүсгэжээ	
—、"Монголросцвэтмет"-ын захирлыг хорих тогтоолыг	
хүчингүй болгожээ	
11-р ХИЧЭЭЛ.....	60
Хар Хорин жишиг хот болох уу, нийслэл байх уу?	
12-р ХИЧЭЭЛ.....	65
—、Цахилгаан гүйдлийн ажил	

二、 Хар алтын тухай	
13-р ХИЧЭЭЛ.....	70
— Дархан цаазтай ан амьтан	
— Монгол улсын амьтдын байршил	
— Бух ба долоон чоно	
14-р ХИЧЭЭЛ.....	75
— Гарын ариун цэвэр	
— Нүдээ яаж арчлах вэ?	
— Бие яаж чийрэгжүүлэх вэ?	
15-р ХИЧЭЭЛ.....	79
— С. Уянга: Сонинынхоо гэрчилгээг би хулгайлж аваагүй.	
— Сэтгүүлчдийг хамгаалах байгууллагууд үүнд ямар хэрхэн хандаж байна вэ?	
16-р ХИЧЭЭЛ.....	85
Дэлхийн 7 гайхамшигаас	
— Хайр дурлалын билэгдэл Таж махал	
— Цагаан хэрэм	
17-р ХИЧЭЭЛ.....	92
Цайны эх орон Шри Ланка	
18-р ХИЧЭЭЛ.....	97
Улсын болон элсэлтийн шалгалтыг хамт авдаг болох уу?	

1-р ХИЧЭЭЛ

“Сая долларын охин” оны шилдэг кино болов

Дэлхийн киноны өртөнцийн тухайн оны өнгийг тодорхойлж, уран бүтээлчид хийсэн бүтээснээ дүгнүүлдэг томоохон сорилгын нэг, Америкийн кино урлагийн академийн шагнал-“Оскар” гардуулах ёслолын ажиллагаа орон нутгийн цагаар ням гаригийн үдэш Калифорни муж улсын Лос-Анжелест 洛杉矶 боллоо.

Өнөө жил 77 дахь удаагаа зохион байгуулж буй киноны уран бүтээлчийн нүсэр 盛大 цугларалтыг хийхээр тус хотын Kodak театрин их танхимыг 柯达剧院 сонгосон бөгөөд донж маяг бүхий гоёмсог даашиinz, хувцсаар олны харц булаах дэлгэцийн баатруудаа тод улаан өнгөт хивс дэвсэн, өнгө гэрлээр гайхуулсан жил жилийн гял цал байдлаар угтлаа.

ЁСЛОЛЫГ ДАМЖУУЛАХААР 150 ОРНЫ ТЕЛЕКОМПАНИ ЭРХ АВЧЭЭ

“Оскар” гардуулах ёслолыг шууд дамжуулах эрхийг АНУ-ын ABC 美国广播公司 телесуваг авсан агаад дэлхийн 150 орны телекомпани орон нутгийн үзэгчдэдээ үзүүлэхээр бүртгүүлсэн байна.

Манай хоёр хөршөөс л гэхэд Оросын “Нэгдүгээр суваг”, Хятадын CCTV-6-гийн Movie Channel энэхүү эрхийг авсан байв. Оросын “Нэгдүгээр суваг” телевиз ёслолын ажиллагааг өнгөрсөн оных шигээ долоон секундээр хоцорч дамжууллаа. Шууд дамжуулахаас татгалзах шийдвэр гарсан нь 2003 онд найруулагч Майкл Мур индэр дээр шагнал гардаж аваадаа Иракт явуулах АНУ-ын дайн хийгээд Ерөнхийлөгч Ж.Бушийг эсэргүүцсэн хилэнт 气愤的 мэдэгдэл хийж, олныг алмайруулсантай холбоотой билээ. Өнөө жилийн арга хэмжээнд хөтлөгч 主持人 Крис Рок 克里斯·洛克 хуран цугласан олны тайван амгалан байдлыг бага боловч эвдэж

орхив. Ёжтойхон үг, гашуун хошигнолоороо зартай жүжигчин эр энэ удаа ч зангаа тавих бодолгүй хэмээн хэдэн өдрийн өмнө ярьж байсан юм.

54 КИНО ӨРСӨЛДӨВ

Наадмын үндсэн номинацуудад 54 кино хүчээ сойжээ. Нэр дэвшсэн номинацын 提名 тоогоор нь шалгаруулсан бол Мартин Скорсезегийн "Авиатор" (11 төрөлд нэр дэвшсэн) тэргүүлэх нь гарцаагүй 毫无疑问 байсан. Хачирхалтай нь энэ манлайллаа батална гэдэгт нь шүүмжлэгчдийн олонхи нь эргэлзэж байсан. Гэвч "Авиатор" таван номинацад түрүүг авчээ.

Үүнээс гадна "Гайхамшигийн орон", "Сая долларын хонгор" кинонууд долоо, "Рэй" зургаа, "Хажуу талд" таван номинацад тус нэр дэвшин, чансаатай бүтээлийн чадал боломжийг харуулсан юм. Үнэхээр ч дэмий нэг, хоёрын хооронд нэр дэвшихийн төлөө нэр дэвшдэггүй, жинхэнэ өрсөлдөөн дунд жаахан эвгүйгээр тодорхойлбол "үхэх сэхэхээ үзсэн алалцаан" дунд энэхүү шалгаруулалт болдог гэдгийг энэ удаагийн наадам бас дахин баталлаа.

Хүүхэлдэйн, баримтат болон богино хэмжээний кинонуудыг эс тооцвол, гол шагналд хүч үзэж буй киноны дийлэнх нь намтарчилсан төрөлд 传记类 хамаарах аж. "Гайхамшигт хүмүүсийн амьдрал"-аас сэдэвлэсэн лав 10 бүтээлийг холливудынхан эвтэй найртай шалгаруулахаар сойсон байна. Таван "Оскар" гардсан "Авиатор" ч тэдгээрийн нэг юм. 77 дахь наадмын бас нэг онцлог нь тухайн төрөлд нэр дэвшсэн бүх уран бүтээлч, жүжигчнийг тайзнаа нэгэн зэрэг үзүүлж, танилцуулахыг хичээсэн явдал.

"ОСКАР-2005"-ЫН ШАГНАЛТНЫЙД ХЭН БЭ?

1. Шилдэг зураач 艺术指导奖- "Авиатор".

"Оскар-2005"-ын эхний шагналыг "Авиатор"-ын зураачаар

ажилласан Данте Ферретти 丹特·菲雷迪, Франческа Ло Скьяво нар гардсан юм. Шагналыг нь "Оскар"-ын шагналт хар арьст гоо бусгүй Хэлл Берри гардуулсан.

2. Шилдэг гол дүрийн эрэгтэй жүжигчин- Жейми Фокс 杰米·福克斯,"Рэй". 《雷》

Энэ киноны гол дүрд тоглосон 37 настай Жейми Фокс хоёр номинацад нэр дэвшсэн юм. Түүнийг гэртээ ядаж ганц "Оскар"-тай харина гэдэгт хэн ч эргэлзэхгүй байсан. Ж.Фокстой шилдэг эрэгтэй гол дүрийн шагнаалд Дон Чидл 唐·切德勒, Жонни Депп 约翰尼·德普, Леонардо ди Каприо 昂纳多·迪卡普里奥, Клинт Иствуд 克林特·伊斯特伍德 нар өрсөлдсөн.

3. Шилдэг гол дүрийн эмэгтэй жүжигчин- Хилари Суонк 希拉里·斯旺克, "Сая долларын хонгор".

Х.Суонк хоёр дахь "Оскар"-аа гардсан нь энэ. Үүний өмнө "Залуус уйлдаггүй" киноны дүрээр "Оскар" баримлыг гартаа анх барьсан.

4. Шилдэг найруулагч 导演- Клинт Иствуд 克林特·伊斯特伍德, "Сая долларын хонгор".

К. Иствуд кинондоо найруулагчаар зогсохгүй, зохиолч, продюсерээр 制片人 ажиллаж, гол дүрд нь тоглосон.

5. Шилдэг туслах дүрийн эмэгтэй жүжигчин-Кэйт Бланшетт 凯特·布兰切特, "Авиатор".

Найруулагч Мартин Скорсезийн 马丁·斯科西斯 кинонд тэрбээр жүжигчин Кэтрин Хепбернийн дурд тоглосон. Уг нь энэ төрөлд Натали Портманыг ("Ойрхон") түрүүлнэ хэмээн олон хүн үзэж байсан юм. Тэрбээр энэхүү хүндтэй өргөмжлөлийн эзэн болоод тайзнаа уг хэлэхдээ "Мартин Скорсезед баярлалаа. Хүү маань таны охинтой гэрлэх байх хэмээн найдаж байна" хэмээн хошигносон.

6. Шилдэг туслах дүрийн эрэгтэй жүжигчин-Морган Фриман 摩根·弗里曼, "Сая долларын хонгор".

Киноны гол баатар эмэгтэйд боксчин болоход нь тусалдаг, хуучны ширэн бээлийтэн явсан залуугийн дүрийг М.Фриман бүтээсэн. Түүнд шагналыг нь Рене Зеллвегер гардуулав.

7. Шилдэг кино 最佳影片- "Сая долларын хонгор".

Найруулагч К.Иствудын бүтээл зургаан төрөлд нэр дэвшсэнээс дөрвөн шагнал гардлаа. Шилдэг киноны төлөө түүнтэй "Авиатор" 《飞行家》, "Гайхамшигийн орон" 《寻找梦幻岛》, "Рей" 《雷》, "Хажуу талд" 《并肩前行》 кинонууд өрсөлдсөн ч "Авиатор" "технизийн", таван, "Гайхамшигийн орон" шилдэг хөгжмийн 配乐, "Хажуу талд" шилдэг сайжруулсан эх зохиолын 改编剧本, "Рей" шилдэг эрэгтэй дүр болон дуу оруулалтаар 音响效果 тус тус "Оскар" авсан юм.

8. Шилдэг зураглаач 摄影-Роберт Ричардсон 罗伯特·理查德森, "Авиатор"

1991 онд тэрбээр "JFK" киногоороо энэ шагналыг гардсан юм.

9. Шилдэг дуу 最佳电影歌曲- "Мотоциклчны тэмдэглэл" 《摩托日记》 киноны "Al Otro Lado Del Pio" нэртэй дуут Уругвайн 乌拉圭 иргэн Хорее Дрекалер бичиж, өөрөө дуулжээ. Гэвч наадамд эл дууг Антонио Бандерас, Карлос Сантьяго нарын дуулснаар танилцуулсан юм. Чухам үүнээс шалтгаалж, гол дүрийн жүжигчин Гаэль Гария Берналь Лос-Анжелест хүрэлцэн ирэхээс татгалзсан байна.

10. Шилдэг монтаж (эвлүүлэг)剪辑- Телма Скупмейкер 塞尔玛·斯库梅克 "Авиатор".

Хатагтай Скупмейкер найруулагч М.Скорсезетэй өмнө нь "Нью-Йоркийн дээрэмчид" зэрэг хоёр ч кинонд хамтран ажиллаж байсан гар нийлдэг хоёр гэнэ.

11.Шилдэг баримтат кино 纪录片- "Эмсийн хүрээлэнд төрөгсөд" 《生于妓院》 .

Зана Бриски 扎纳·布里斯基, Росс Кауфманн 罗斯·考夫曼 нарын энэ бүтээл "Камертай хүүхдүүд" хүмүүнлэгийн 人道的 төслийн нэг хэсэг аж. Уг төсөл дэлхийн хамгийн ядуу хотуудад амьдардаг хүүхэд, өсвөр үеийг авьяасаа илрүүлэхэд нь туслах зорилготой аж.

12. Шилдэг богино хэмжээний, хүнжүүлсэн кино 动画短片 - "Райан" 《瑞恩》.

Канадын Крис Ландретын бүтээл энэхүү хүүхэлдэйн киноны гол баатар нь өнгөрсөн зууны 60-70 онд нэрд гарсан Канадын авьяаслаг зурмал кино'бүтээгч Райан Ларкин юм байна.

13. Шилдэг хүүхэлдэйн кино 动画长片 - "Итгэмээргүй юм" 《超人总动员》

"Pixar" компанийн бүтээл энэ кинонд найруулагч, кино зохиол бичигчээр ажиллаж, дуу оруулсан Брэд Берд 布拉德·伯德 шагналаа хүлээн авлаа. Тэрбээр энэ жил хоёр ч номинацад нэр дэвшжээ. "Итгэмээргүй юм" энэ төрөлд "Аварга загасны үлгэр", "Шрек-2" 《怪物史莱克 2》 -той өрсөлдсөн байна.

14. Шилдэг нүүр хувиргалт 化妆- "Лемоний Сникет. 33 азгүй явдал" 《雷蒙斯尼奇的不幸历险》.

Тус кинонд ажилласан Вэлли О'Рейли, Билл Корсо нар анх удаагаа "Оскар"-ын эзэд болов.

15. Шилдэг хувцасны загвар 服装设计-Сэнди Пауэлл.

"Авиатор"-ын баатруудыг гоёсон энэ дизайнер 服装设计师 өмнө нь "Нью-Йоркийн дээрэмчид" кинонд М.Скорсезетэй хамтарч ажилласан.

16. Хүндэт шагнал 终身成就奖- Сидни Люмет 希德尼·鲁迈特.

Кино урлагт оруулсан хувь нэмрийг нь үнэлэн олгодог энэхүү эрхэм шагнал найруулагч Сидни Люметэд очлоо. Америкийн сонгодгуудын нэг тэрбээр "Баяртай, Бравериан (1968), "Цахлай"海鸥 (1969) зэрэг олон киногоороо нэрд гарсан. Аль Пачино ноён

Люметэд "Оскар"-ыг нь гардууллаа.

Дасгал:

1. 77 дахь "Оскар" гардуулах ёслол хэзээ хаана болсон бэ?
2. Энэ жилийн "Оскар" гардуулах ёслолыг шууд дамжуулах эрхийг аль телесуваг авсан бэ? Монгол улс энэхүү эрхийг авсан уу?
3. Энэ удаагийн киноны наадмын хөтлөгч хэн бэ?
4. 77 дахь киноны наадмын номинацад нийтдээ хэдэн кино нэр дэвшигдсэн бэ? Үүний дотор "Авиатор" хэдэн төрөлд нэр дэвшсэн бэ?
5. 77 дахь наадмын онцлогийг товчхон ярьж өгөөрэй.
6. "Оскар-2005"-ын шилдэг гол дүрийн эрэгтэй эмэгтэй жүжигчин хэн бэ? Шилдэг кино нь аль кино вэ?
7. Наадмын бусад шагналтнууд хэн бэ?
8. 1-2-р бадгийг хятадаар орчуул.

2-р ХИЧЭЭЛ

—. XXI зуун Хятадын зуун болохгүй!

Саяхан Хятадын телевиз /CCTV/-ээр "Өнөөдөр Хятадын 300 хот цэвэр усны дутагдалд орж, дунд сургуулиуд гар хувингаар усаа зөөж байна...", "Зүүн Хятадад жил бүр үер болж үүний улмаас Хятадын аж үйлдвэрийн 1/3 буюу 240 тэрбум юаны хохирол үзэж байна" гэсэн мэдээ нэвтрүүлж, "Хэрэв газрын тосны нөөц дуусвал хүн төрөлхтөн энергийн 能量, 能源 шинэ эх үүсвэр олж болох юм. Харин усны нөөц дуусвал бид хэрхэх билээ?" хэмээн сэргэжилүүлэн сануулж байсан.

Сүүлийн хэдэн жилд Хятадын эдийн засаг эрчимтэй өсөж байгаа гэдэгтэй бүх л улс орнууд санал нийлдэг. Хятадууд ч ирж буй 21-р зууныг "Хятадын зуун болно" хэмээн бардамнадаг 骄傲, 自豪 билээ. Иймээс Хятадын мэдээллийн хэрэгслүүд "Хятадыг гадаадын империалист улсууд 帝国主义国家 өзөрхийлж байсан, харин одоо бол Хятад супер хүчирхэг улс болж байна. Өнөөдөр Хятадад айх аюул байхгүй." гэсэн ухуулга сурталчилгаа 宣传 хийсээр байна.

Хятадууд үүнийгээ зөвхөн хэлж ярих бус хийж, хэрэгжүүлж байна. Их Британиас Хонгконгийг авлаа, Төвдийн асуудлыг шийдчихлээ, одоо Тайвань... Өдгөө Монголд ч Хятадууд нэвтэрч 渗透 байна. Тухайлбал, нийгмийн амьдралд улс төрийн болон эдийн засгийн аргаар нөлөөлж байна.

Хятадууд Монголыг танкаар бус худалдаа наймаагаар, хамтарсан компаниудаар болон бизнесменүүдээрээ эзлэхээр төлөвлөж байна бус уу? Энэ бардам хандлагыг 傲慢态度 зөвхөн Хятадад оршин суудаг нь ч бус, гадаад оронд цагаачлан суугаа 侨居 хятад иргэд ч гаргадаг. Тэд нээлттэйгээр "21-р зуун Хятадын зуун болно, үүнд бид ч гэсэн өөрсдийн хувь нэмрээ оруулах ёстой" хэмээн хэлдэг бөгөөд Хонгконг, Тайвань дахь хятадууд ч

Бээжингийн бодлогыг дэмждэг ажээ.

Өнөөгийн АНУ-д байгаа хятад цагаачид Америкийн улстөрд нэвтрэхийг хүсэх болжээ. АНУ-д хэвлэгддэг бараг бүх хятад сонин, сэтгүүлүүд Бээжингийн бодлого болон Их Хан үндэстний шовинист үзлийг 沙文主义 хөхүүлэн 兴奋，振奋 дэмждэг байна.

Хятадууд эдийн засаг хүчтэй хөгжих буй, мөн дэлхийн хамгийн том үндэстэн гэдгээрээ бахархдаг. Иймээс ч Монголын зарим улстөрчид, эрдэмтэд Хятадын сүр хүчээс эмээн, ирэх зууныг "Хятадын зуун" болно хэмээн уулга алдах 惊呼; 说胡话 боллоо. Харин 21-р зуун Хятадын зуун болох болов уу? Тэгвэл Хятад Азийн номер нэг гүрэн болно? Дараа нь дэлхийн?

Харин миний хувьд эсрэг саналтай байна. "Баримт түшье." Өнөөдөр Хятадад дөрвөн том аюул байна. Үүнд хүн амын хэт өсөлт, байгалийн нөөц баялагийн хомсдол 贫乏, хүрээлэн байгаа орчны бохирдол, экологийн 生态 тэнцвэргүй байдлыг нэрлэж болно. Өнөөдрийн эдийн засгийн өсөлт бол Хятадын байгалийн баялагийн сүүлчийн нөөц, ялангуяа ургамлын аймаг бол бараг устсан 消失殆尽.

Түүнчлэн 21-р зуунд Хятад хүн амын өсөлтийг торгоож хүчрэхээ 强行控制 байж, хүнс тэжээлийнхээ 10%-ийг импортолдог болно. Энэ бол АНУ-ын хүн амын 50%-ийг хангах хүнсний импорт эсвэл Японы хүнсний нийт импорттой тэнцүү хэмжээний гэсэн үг.

АНУ-ын Дэлхий судлалын хүлээнгийн "2030 онд Хятадын хүн ам хэрхэн өсөх вэ?" илтгэлд өнөө үед Хятад улс жил бүр гадаадаас хамгийн багадаа л гэхэд 378 сая тонн хүнс худалдаж авах хэрэгцээ гарч байна. Энэ бол дэлхийн хамгийн том импортлогч гэдгийг харуулж байна" гэсэн байдаг. Заримдаа хүнсний бүтээгдэхүүн импортлоход мөнгө нь хүрэлцэхгүй болж байна. Сая сая хятадууд өлсөж байна.

Одоо Хятадын Хуавэй бүсийн олон гол мөрөн татарч 減少

байна. 2020 он гэхэд Шар мөрний урсгал багасч, мэдэгэдэхүйц татарсаар.

Түүнчлэн шинэ зуунд Бээжин хотын газар доорх усны нөөц дуусах ажээ.

Магадгүй үүний улмаас нийслэлээ нүүлгэх эсвэл өөр хотыг нийслэл болгох шаардлага ч гарч болох. Тэгвэл Бээжин хотын 10 сая хүн амыг хааш нь нүүлгэх вэ? Хувавэйн бүс нутгийн хэдэн зуун сая хүнийг хэрхэх билээ. Хэрэв түүний аюул хөнөөлийг 危害 энэ ард түмэнд мэдэгдэвэл бөөн үймээн сандрал 骚乱和恐慌 болно.

Их нүүдэл хөдөлгөөн, том эвдрэл сүйрэл 灾难 айсуй 接踵而至. Дотоод байдал нь улам бүр тогтвортгүй болж байгаа бөгөөд Шинжаан, Бээжин, Төвдөд янз бүрийн хөдөлгөөн гарах болж, Төвд, Зүүн Түркестан, Өвөрмонголд салан тусгаарлах үзэл газар авсаар 盛行, 猖獗. Үүнийг Хятадын Засгийн газар хүчээр л дарж чадаж байна.

Хэрэв энэ үймээн сандрал газар авч өргөжвэл олон сая иргэд орон гэрээ орхин хөрш орнууд руу дүрвэнэ. Магадгүй өлсгөлөнд нэрвэгдсэн сая сая хятадууд Вьетнам, Лаос, Бирм, Казахстан, Монгол, Сибирь, Солонгос, Япон руу гарна. Энэ бол зүүд 幻想 биш бодит зүйл. Хятадын энэ олон сая цагаачдад Монгол улс хэрхэн хандах вэ? Үүнийг одооноос бодож байх хэрэгтэй.

Иймээс 21-р зуун Хятадын зүүн болохгүй харин олон туйлт 多极 дэлхий ертөнц хэвээр байх болно.

二 . Монголын.gov хөтөлбөрийн түүхийн түүхийг хүсч байна.

Монголд хамгийн их хөрөнгө оруулж байгаа хүмүүс бол хятадууд. Тэр хирээрээ 尽力, 努力 ч далд зорилгоо хэрэгжүүлж байгаа. Түүний бэлээхэн 现成 жишээ нь Нийслэлийн хаяа Налайх

тосгон билээ. Налайхыг сүүлийн үед хятадуудын тосгон гэж ярьж бичицгээж байна. Тэгэхээс өөр арагуй байдал Налайхад харагддаг. Хятадуудын хөрөнгө оруулалт орж ирлээ гээд тэнд ажилгүйдэл буураагүй. Харин ч янхандалт, архидалт, мөрийтэй тоглоом 赌博, хар тамхины наймаа гээд сөрөг үзэгдэл газар авсан. Бас хятадууд хөрөнгө оруулалтаа дагуулаад ажиллах хүчээ оруулаад ирдэг. Хятадуудын энэ бүх далд бодлогыг манай төр засгийн цагаан 诚实的 захтанууд огт ойлгохгүй, ойлгосон ч ямар ч арга хэмжээ авахгүй байна. Тэдний олон сая төгрөгийн хөрөнгө оруулалтын тоо, жагсаасан нууц төлөвлөгөөг хятадуудын бодлого хэрэгжиж тэд хэзээ нэгэн цагт эзэн суугаад авдаг. Энэ нь нөгөө хятад ухаан нь юмсанж. Үүний тод жишээ бол Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёрын нүдэн дээр хятадуудын туршилтын туулай болж байгаа Налайх юм. Гэтэл сүүлийн үед гар бариад бугуй барина гэгчээр Налайхыг чамласан 不知足 хятадууд Монголын.govьд эзэн суухыг хүсч байна. Монголын.govийн өмнөд бүсэд хөрш Хятадад гурван жил экспортлох хэмжээний буюу зургаан тэрбум тн нүүрсний нөөц байгаа гэнэ. Хятадын нүүрс олборлодог хамгийн том компани Монголд ашигт малтмал олборлох, боловсруулахаар хэлэлцэж байгаа юм байх. Яах аргагүй хужаа 汉人 ухаан мөн байгаа биз. Хятадууд "Монголчууд манайхныг дангаараа эзэмших гэвэл зөвшөөрөхгүй байж мэднэ" гэж тооцоолоходоо 盘算 болгаруудаар зуучлуулж 做中间人 байгаа юмсанж. Хятадууд ийм өнгөлөн далдлалт 伪装, 隐蔽 хийж байгаад монголын баялгийг гурван жил ухах лиценз 许可证 авчихвал гурван зуун мянган хужаа залууг Өмнийн цэнхэр.govийн ганц айлуудаар тарааж хүслээ гүйцээнэ. Түүнийг дагаад хятадын балгас 城镇.govийг бүрхэж монголчуудад зориулсан хятад соёл түгэн дэлгэрч гурван жилийн лиценз нь гучин жилийн зөвшөөрөл нь 300 жил монголын.govийг эзэгнэх 占有, 控制 дархан эрх болно.

Гурван зууны дараа Хятадын засгийн газар " Бид он удаан жил амьдарсан нутгаа авна. Энэ говь чинь Хятадынх шүү дээ" гээд дэлхийд зарлаж цэргүүдээрээ хамгаалуулна. Хятадуудад улс төрийн ийм баялаг туршлага байгааг өнөөдөр бид Гонконг, Тайванаас харж суугаа шүү дээ. Бодит байдал ийм байхад манайхан хэрхэн хандаж байгааг сонирхоё. Олборлогч компаниуд засмал болон төмөр зам тавих цахилгаан станц, авто машины сэлбэгийн 零件 үйлдвэрүүд баривал татварын хөнгөлөлт үзүүлнэ гэж Монголын үйлдвэр худалдааны сайд ноён С. Батболд мэдэгдэж байна. "Оюу толгой"-н зэсийн баяжмалын үйлдвэрийг эрчим хүчээр хангахын тулд цахилгаан станц барих бөгөөд "Таван толгой"-н нүүрсний 60 хувийг энд ашиглаж, үлдэх 40 хувийг хятадуудад худалдана гэж Өмнөговийн нүүрсний нөөцийг эзэмших эрхтэй Монголын компанийн захирал Ц.Тогoo гэгч тунхаглаж байна. Эрхэм дээдсүүдийн үг яриа хятадуудын загатнасан 渴望 газар нь маажих 刮去 шиг болоо биз. Хамгийн гол нь эрхэм сайд, захирлууд тавь, зуун жилийн дараах говийн амьдралаа төсөөлөн харж 预见, монголын ирээдүйн үр садын аюулгүй байдлыг тооцоо 考虑 болов уу. Өглөгч 慷慨的 баян эх орныхоо өмнөд хормой 衣襟 их говийнхоо ашигт малтмалын нөөцийг өөрийн толгой мэдрэлтэй байгаа дээрээ үрэн таран хийлгүй 挥霍无度的 улсын төсөөвт жаахан мөнгө тусгахыг бодмоор юм. Олон тэрбум төгрөгөөр хэмжигдэх өмнөд говийн эрдэсийн 矿物 асуудал Монгол улсын эрх ашиг, үндэсний аюулгүй байдалд илэрхий хамрагдах 包含 бодлогын асуудал гэж молхи (болхи) 愚笨的 бичээч би ойлгож байна. 2003 оны намар монголын хэдэн сэтгүүлч, урлаг соёлынхон Өмнөговь аймгийн хил залгаа 边境线 өвөрмонголын өөртөө засах орны хоёр хошуугаар явж билээ. Тэндхийн аймгийн коммунист намын хорооны дарга бидэнд ярилцлага өгөхдөө дээрх асуудлыг хөндөж "Монголын тал бидний

саналыг авахгүй бол эдийн засгаар нөлөөлнө" гэх ухааны юм ярьж байж билээ. Тэгэхээр манай говь руу хөрөнгө хаях асуудал Хятадын тэр засгийн удирдлагуудын бүр дээрээсээ дордоо хүртэл толгойн өвчин болж байгаа нь ойлгомжтой байгаа юм. Харин монголчууд тэр хэргийн алсын бодлогыг бодолцох л хэрэгтэй болох нь ээ.

Дасгал:

1. Саяхан CCTV-ээр нэвтрүүлж гаргасан энергийн тухай мэдээ нь юу ярив?
2. Яагаад 21-р зууныг "Хятадын зуун болно" гэж хэлж байна вэ?
3. Тус өгүүллийн зохиолч 21-р зууныг "Хятадын зуун болно" гэдгийг зөвшөөрсөн үү? Учир шалтгаан нь юу билээ?
4. 4, 5-р бадгийг хятдаар орчуул.
5. Хятад бол монголд их хөрөнгө оруулж байгаа орнуудын нэг юм аа. Харин зарим монголчууд яаж үзэж байна вэ? Жишээ татаж ярилц.
6. Хятадчууд голдуу монголын ямар аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийж байна вэ?
7. Налайх, Оюу толгой гэдэг нь ямар газар вэ? Тэнд хятадчууд олон байна уу үгүй юу?
8. "Олон тэрбум төгрөгөөр..." -ээс хятадаар орчуул.

3-р ХИЧЭЭЛ

— Д. Сүхбаатар

Монгол хувьсгалын их удирдагч 伟大领袖 Дамдин Сүхбаатар 1893 оны хоёрдугаар сарын хоёрны өдөр одоогийн Амгаланбаатар хотод ядуу ард Дамдин гэр бүлд төржээ. Сүхбаатарын эцэг Дамдин, эх Ханд хоёр ядуу малчин байлаа. Тэднийх 1890 оны үед нийслэл Хүрээнд нүүж иржээ.

Сүхбаатар ухаантай, аав ээждээ их халамжтай хүүхэд байлаа. Сүхбаатар янз бүрийн ажил хийж эцэг эхдээ тусалдаг байв. Сүхбаатар 14 настай байхдаа Жамъян гүн гэдэг хүнээр монгол бичиг, тоо заалгаж, сайн сурчээ. Бас тэр үед нийслэл Хүрээнд сууж байсан орос ажилчдын хүүхэдтэй танилцаж, завтай цагтаа тэдэнтэй тоглодог байсан учир оросоор сайн ярьж сурчээ.

Сүхбаатар бага наснаасаа Монголын ард түмний хүнд амьдралыг нүдээр үзэж, тэдэнд эрх чөлөө олгохыг хүсдэг байлаа. 1919 оноос эхлэн нийслэл Хүрээний (одоогийн Улаанбаатар) **хэвлэх үйлдвэрт** 印刷厂 ажиллах болж, тэнд ажиллаж байсан оросын хувьсгалчидтай танилцжээ.

Сүхбаатар хэвлэх үйлдвэрт ажиллаж байхдаа хувьсгалт нууц бүлгэм 秘密小组 байгуулжээ. Сүхбаатарын байгуулсан тэр нууц бүлгэм нь Монгол Ардын Хувьсгалт Нам(MAXH) болон хөгжиж эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж байсан монголын ард түмний тэмцлийг удирдав. 1921 онд ялсан Монгол ардын хувьсгал монголын ард түмэнд эрх чөлөө олгосон юм. Одоо MAXH-аар удирдуулсан монголын ард түмэн эх орондоо социализмыг амжилттай байгуулж байна.

— Жанжин Сүхбаатарыг оросууд хорлосон нь улам бүр батлагдсаар байна

Дамдин Сүхбаатарын хүү Галсанлхүндэв /олон нийт Галсан